

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Жаалхүү	Дугаар	L239
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Гурвантэс сум
Төрсөн газар	Гурвантэс сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Засаг даргын орлогч		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Гоёотын хурал, Овоотын хийд, Зүүн уужим хурал, Цагаан суварга хурал, Нэмэгтийн хурал, Тостын хурал	Сүм хийдийн дугаар	ӨГГТ 009, ӨГГТ 012, ӨГГТ 010 , ӨГГТ 011
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 9	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нэмэгтийн хурал, Тостын хурал, Гоёотын хурал, Зүүн уужим хурал,
Овоотын хийд

Гантулга: За Гурвантэс сумын засаг даргын орлогч Жаалхүү гуайтай тахилгат , нутгийнх нь тахилгат уул усных нь талаар ам мэдээ авах гэж байна аа. За та өөрийгөө танилцуулна уу?

Жаалхүү: За би Гурвантэс сумын засаг даргын орлогч Жаалхүү гэж хүн байна аа. За 1977 онд Дундговь аймгийн Хөдөө аж ахуйн техникум төгссөн. Арван долоон жил малын эмч хийсэн. За энэ албандаа арав дахь жилдээ ажиллаж байна, засаг дарыгн орлогчоор. За манай нутгийн тахилгатай уул усыг ингээд судлаад үзэхлээр зэрэг хоёр гурван тахилгатай овоо байдаг. За нэг нь тэр Тост хайрханы тахилгатай овоо гэж байдаг. За тэр тахилгат овоог тахиад , дараа нь одоо уулын энгэр дээр Наран гэж ус байдаг.Тэр Наранг тахиад, тэгээд шуурга энэ тэрийн хойно, бүр Хөвдийн голын тэнд Хөвд гэдэг газар, гол байдаг.Тэр голыг тахиад, за тэгээд энэ тахилгыг хийж дууссаны дараа Нэмэгт гээд уул байгаа. Нэмэгтийн баруун үрд бол тэр Хийморийн овоо гэж байдаг.Тэр овоог тахиад, за тэгээд наана нь Цэцээс гээд ус байдаг. Тэр усыг тахиад, тэгээд өмнө нь манайх араар нь хоолойтой,

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

гурван...Цэцээс гэдэг чинь одоо Тэсийн гурван голын нэг урт гол байгаа.Тэр голын баруун үзүүр дээр одоо Наран даац гэж үс байдаг.За тэр усыг тахиад, за энэ үйлдлийг хийсний дараа бол тэр гороо бууж ирсэн одоо тэр нь бол байгалийн гамшиг аюул энэ тэрээс хамгаалж тэгээд Ноён Богд гэдэг уулыг тахидаг.За энэ бол их догшин газар. За тэрийг мэдээж тэгэхээр ус, хур их буухаар аргадаж, тэрийг одоо багасгах талаас нь тэр Ноён Богдыг тахидаг.Тэгээд энэ Баюуны хошууны овоо гэж Зүүн сайхны зүүн үзүүр дээр, одоо би нэрийг нь сайн мэдэхгүй байна.Тийм овоо байдаг.За тэр овоог хамгийн сүүлд нь тахиад.За тэгээд баруун урагшаа бол баруунтаа одоо хурта, өнтэй сайхан байдаг ахмадууд бол ярьдаг юм. За түүний нөгөө талаар одоо энэ Тост хайрхны дээд шил дээр одоо тав зургаан км-т бас нэг одоо жижигхэн замын сумын, дацан дуган хийд байсан гэж ярьдаг юм. За тэндхийн лам нар болохоор энэ төр одоо эсэргүү энэ тэр гээд лам нарыг хөдөлгөөд яах үеэр тэнд ажиллаж байсан лам одоо хоёр бодь гөрөөс алаад, ер нь одоо энэ Тостын хийдийг баян чинээлэг малтайгаар одоо бүх юмыг нь тэгш явуулъя гэж, хоёр бодь гөрөөсийг алаад, тэгээд энэ уулын хойд бас нэг хуц байгаа юм. Тэр хуц тал газар одоо тэр агуй тахисан гэж ярьдаг юм. Тийм одоо домог байдаг юм, тэр бол чухам хэр үнэмшилтэй юм мэдэхгүй юм.За тэр хүний хүү нь одоо тэр Балган гэж лам хүн байдаг юм.За тэр лам одоо хорин хэдтэй л байсан байх. Хорин хэдтэй л одоо бодь гөрөөс алж тэр талын юуг тахиж байхад, одоо агуйг тахиж байхад оролцож байсан гэж ярьдаг юм. Аа тэрүүний хүү нь одоо Даваа гээд жаран хэдтэй хүн байгаа. За та нар тэр Даваа гуайтай уулзаж бас бус зүйлүүдийг тодруулна биз дээ.За нөгөө талаар ингээд ер нь бол ингээд уул үс овоог тахихад бол ингээд.Тус тусдаа ингээд номтой байдаг гэж.Одоо хэдийгээр тэр ном нь бол манай энд олдохгүй байна. За хамгийн сүүлд одоо ерэн найман онд энэ Гоёотын хийдэд, тэр үедээ бол одоо юу гэдэг юм бэ дээ, нөгөө хөтөч мөтөч хийдэг хүнийг чинь...

Гантулга:Сойвон

Жаалхүү: За одоо тийм туслах хүн байсан.Тэр үедээ одоо тэгээд лам нарын хөтөч мөтөч хийгээд явдаг хүн байсан.За тэр хүн бол ерэн есөн онд бол одоо хамгийн сүүлд тэр Хийморийн овоог тахисан.За тэр өвгөнтэй бол ингээд цуг явж байхад бол тэр өвгөн чинь наян хэдтэй өвгөн байсан.Тэгээд тэр өвгөнтэй бол ингээд яваад тэр овоон дээр очиход бол урд нь бол одоо хоёр гурван удаа тэр овоог тахиж байхад оролцож байсан.Тэгэхэд бол одоо тэрэн дээр хийж байсан зан үйл, тэр өвгөний сүмд хийж байсан зан үйл бол маш өөр байсан.За тэр өвгөн болохоор зэрэг, тэр овоон дээр гарчихаад, маш их шуургатай байсан. Тэр өвгөн ном уншаад хэсэг суусан.Тэгээд одоо шуургыг нь жаахан болихгүй бол болохгүй нь ээ гээд одоо ном уншаад суугаад байсан.Тэгээд тэр овоон дээр чинь бол нэг тахихдаа тэр чинь морь уралддаг , бөх барилддаг тэр чинь сүрхий, тийм хийморийн...

Гантулга: Их даллагатай?

Жаалхүү: Тийм газар байгаа юм.Тэр чинь ганц ийм нүцгэн толгой, тэгсэн мөртлөө дээр нь маш том ийм арц овоо босгочихсон тийм газар байдаг юм.Тэгээд маш өндөр өө, өндөр гэж байгаа.

Гантулга: Дээрээ тавцан дээрээ тэгшхэн гэж байгаа билүү?

Жаалхүү: Тийм, тавцан дээрээ яг тэгшхэн. Одоо өчигдөр та нар тэр Дүнд овоог үзлээ ш дээ.

Гантулга: Тийм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жаалхүү: Тиймэрхүү.Тэгээд тэр морь мал уралддаг газар нь жаахан өгсүүр л дээ, гэхдээ.Тэгээд бөх энэ тэр барилддаг тийм талбай малбайтай тийм л газар байдаг юм. Тэгээд тэр өвгөн болохлээрээ зэрэг салхи болохгүй гээд л салхи, ном уншаад байсан.Тэгээд л тэгж байж байгаад л өө энэ элс нь алга байна гээд л бас ном уншаад унасан, тэр нь ямар ч ном байсан юм.Тэгж байгаад тэр нөгөө ариутгалын сан ман энэ тэрээ, тэгээд тэрэн байгаа бүх шил энэ тэрийг цэвэрлүүлээд, тэгээд тэр баруун хойшоо агуйд аваачиж, болж байна гээд газар мазрыг нь зааж хийсэн. Тэгээд ирээд арц хүж тавиад баахан л ном уншсан, одоо ямар ч ном байсан юм.Би тэрийг нь сайн мэдэхгүй юм.Тэгээд дараа нь бид нар чинь морио уралдуулсан, бөхөө барилдуулсан.Тэгээд л тарцгаасан даа.За тэр овоог тахиж байхад дор байгаа улсууд яаж байдаг вэ гэхлээр дандаа л нөгөө хадагны дээж өргөж байдаг ёстой юм гэнэ лээ. Сүүтэй цай май ерөөсөө өргөж болдоггүй, суу хүргэж болдоггүй л гэж ярьдаг байсан юм л даа. Урьд нь болохлээр сүүтэй цай, айраг майраг аваачаад л цацдаг барьдаг янз бүрийн юм байсан л даа.Аа тэгж байхад бол огт тийм юм байгаагүй, тэр өвгөн ерөөсөө л ...За тэгээд л улсууд чинь архи аваачина, үгүй ээ алив, зарим нь тэгээд л уучихдаг байсан байхгүй юу.Тэр өвгөн бол тэндээс ганц ч архи балгаагүй. Ямар ч байсан миний мэдэж байгаагаар бол арваад шил архи, арваад литр монгол архи байсан.Бүгдийг нь сэргим өргөчихсөн. Тэнд өргөөд ир, энд өргөөд ир гээд л битонд хийгээд явуулна.За тэгээд л тэрүүнээс хойш долоо хоногийн дараа янзын сайхан бороо орсон доо. Ер нь тэгээд л үгүй ээ, энэ чинь цаг сайжраад, сайхан зуншаад л, тэгээд тэр нэг хоёр гурван жил чинь манай сум мал тооллогоор зуун жар, далан мянган мал тоологдсон.Тэгээд л хоёр мянга нэг , хоёр онд зуд болоод л тэгээд л байхгүй.Одоо манайх чинь тавиад мянган малтай , дөнгөж ерээд мянган малтай л болж байна.

Гантулга: Одоо энэ тэр Зүүн уужмын Балган гуайн тухай дуулсан юм байвал?

Батмөнх: Харин Балган гуайнд орох хүн чинь ямар ч байсан их номтой хүн байдаг юм гэнэ лээ гэж дуулсан.Тэгээд ямар ч байсан тэр сүм энэ тэр тарахад хоёр бодь гөрөөс алж тэгээд тэр талбай руугаа тэр агуйг тахиж, тэрүүгээрээ бол одоо энэ Тостынхон бол баян чинээлэг мал сайтай, одоо бүх юм тэгш явна л гэж ярьсан гэж би хүнээс дуулсан.

Гантулга: Ер нь танай сум чинь хичнээн багтай байна, энэ яриад байгаа нутаг ус чинь сумынхаа аль багд, тэгээд энэ сумаасаа зүгээр яривал зүүн тийшээ, баруун тийшээ гээд яривал? Саяны ярисан газрууд?

Жаалхүү: За саяны ярисан газрууд бол тэр Тост гэдэг чинь бол сумаасаа баруун тийшээ гучин км-т оршиж байна.За Нэмэхт гэдэг нь одоо сумаасаа баруун урагшаа за нэг далан км-т оршиж байх юм даа.

Гантулга: Тэгээд л энэ хоёр газар л ?

Жаалхүү: Тийм, энэ хоёр газар л.

Гантулга: Гол нь?

Жаалхүү: Тийм, гол нь. За тэгээд одоо энэ Овоотын хийд гээд их том хийд бас юу байсан гэсэн. Тэр Овоотын баруун дээд эхэн дээр нь бас Суварга гээд газар байдаг юм. Бас агуйтай, одоо тэр бол нэг ёсондоо лам хөдөөлнө гэж ярьдаг ш дээ. Бясалгал хийдэг...

Гантулга: Бясалгал хийдэг?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жаалхүү: Тийм, бясалгал хийдэг тийм л газар байсан юм болов уу. Аа тэгээд тэрүүнийхээ хажууд бас жижиг дугантай. Тэгээд тэр дуган дээрээ одоо ном момоо уншаад тэгээд бясалгал хийхлээрээ одоо тэр агуй дээрээ очиж хийдэг байсан юм болов уу л гэж одоо ойлгодог юм ш дээ. Одоо тэгээд түүх мүүх сайн мэдэхгүй юм даа.

Гантулга: Тэр Галсандаш гуайн тухайд?

Жаалхүү: Тэр Галсандаш гуай гэдэг хүн бол Овоотод бол одоо юу...

Гантулга: Овоотын хурал дээр?

Жааохрүү: Овоотын хурал дээр шавилан сууж байсан юм. Тэнд, тэрийг болвол би сайн мэдэхгүй юм. Энэ талаарх мэдээллийг бол тэр аймгийн Чингэс хаанын академийн гишүүн Батням гээд нэг хүн бий. Бас л нэгдлийн дарга олон жил хийсэн. Бас гарын үр дүйтэй. Тэр хүнээс бол бас тодруулга хийвэл бас илүү юм хэлэх болов уу гэж бодож байна.

Гантулга: Санжшарав гуайн тухай та юу мэдэх вэ?

Жаалхүү: За Санжшарав гэдэг хүн бол намайг малын эмч болоод ирэхэд бол энд намын гишүүн хийдэг ийм л хүн байсан. Тэгээд лам хүн гэдэг нь энэ өөрчлөлт шинэчлэлт, ерэн оноос хойш л тодорсон. Тэгээд тэр үед ингээд судлаад үзэхлээр зэрэг бас нэлээн эртнээс тэр тарни марни, тэр юм хумаа энэ тэр аргалж тасрахгүй хийж байсан хүн юм билээ.

Гантулга: Хурал номоо үргэлжлүүлж байсан?

Жаалхүү: Тэр нь болохоор их нууц байж байгаад л тэгээд л ерэн оноос хойш жинхэнэ ил гарч олон түмэн мэдэж, ном зом уншиж...

Гантулга: Тэр Чимэд гуай гээд бас тэр ах нь байсан гээд нэг хүн тухай...?

Жаалхүү: Тийм, Лувсангончиг гээд. Тэр Лувсангончиг гэдэг хүнийг мэднэ гэдэг тэр хүн нь болохоор би ёстой мэдэхгүй гээд, тэр хоёр өвгөн ерөөсөө юм ярьдаггүй юм.

Гантулга: Та ер нь нутгийн энэ тахилга юуны судар байна ш дээ, тэр үрд нэг байсан гээд сураг дуулсан гээд түрүүн?

Жаалхүү: За энийг болохоор тэр наймдугаар гэгээн Жасрай гэдэг хүн, бас энэ сум нэгдлийн дарга олон жил хийж байсан Хайвжунай гээд одоо лам хүн. Тэр хүн бас байнга тэр хүнтэй уулзаж, наашаа цаашаа явдаг. Тэгээд тэр хүнд тийм яриа гарсан байна лээ л дээ, чухам үнэн худлыг нь мэдэхгүй. Баянбогдийг тахидаг судар чинь манайд байгаа шүү гэсэн юм гэнэ лээ.

Гантулга: Тэр гэгээн бол одоо Өвөрмонголд байна уу?

Жаалхүү: Тэр гэгээн бол одоо Өвөрмонголд байна. Гэхдээ яг тэр байгаа газар нь бол одоо Зүүн хошуу гээд...

Гантулга: Зүүн хошуу?

Жаалхүү: Тийм. Тэр Баянуурт байдаг юм уу, Хэнтийд байдаг юм уу тэр хавьцаа л байдаг юм шиг байгаа юм. Тэгээд бас тэр Далайн үүдээр байдаг. Одоо бол тэр Далайн үүдээрээ бол сум орон сууц барьчихсан их л тохилог байдаг юм байна лээ, би бас очиж байсан. Тэгээд тэр наад хүү нь бол одоо Сүхээ гээд эмч бий. Хүү нь бараг байран байдаг. Тэгээд хил нээгдээд бас Халхынх нь улс наашаа ороод ирдэг юм шиг байгаа юм. Тэгж

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байгаад тэр цаашаа хошуу руугаа явчихдаг.Тэгээд эд нар чинь Зүүн хошуу гэж ярьдаг. Тэгээд би Баяннуур , Хэнтий хавиар байдаг юм болов уу гэж...

Гантулга: Аа өөрсдөө тэгж ярьдаг?

Жаалхүү: Тийм.Тэр Зүүн хошуу, Баруун хошуу гэж ярьдаг.

Гантулдга: Хуучнаар?

Жаалхүү: Тийм, тиймэрхүү л юм байна. Өөр ч одоо нэг их дуулж сонссон юм...

Гантулга: За баярлалаа.

Жаалхүү: За зүгээр.